

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ  
үнэлгээний хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдрийн 3-ийн дугаар албан  
бичгийн хавсралт



ЗӨВЛӨМЖ

2023 оны 03 дугаар сарын 29

Арвайхээр

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны  
үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ  
үнэлгээний тухай

### Нэг. Зорилго

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Үндэслэл, арга зүй

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлберийн хэрэгжилт
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

-Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт  
-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлберийн биелэлт

-Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

-Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хувийн хэвшлийг дэмжсэн байдал

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- Байгууллагын ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн үнэлгээ
- Шударга байдлын түвшний үнэлгээ
- Шилэн дансны хөтөллөтийн үнэлгээ
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт
- Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:

-Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт зэрэг 13 үзүүлэлтийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6,2, 6,3-т заасан арга зүйгээр дээрх 13 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулга авах, хамааралтай баримт бичиг болон статистик мэдээллийн дүнтэй харьцуулалт хийсэн болно. Мөн 2021 оны үйл ажиллагаанд ёгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцоходоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт нийт үнэлгээний 50 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт 15 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 5 үзүүлэлт 20 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ болох 1 үзүүлэлт 15 хувиар тус тус тооцсон болно.

Эдгээр үзүүлэлтээс Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Шударга байдлын түвшний үнэлгээг Хууль, эрх зүйн хэлтсээс авч ашигласан болно.

Баян-Өндөр сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр ерөнхий үнэлгээ 84,8 хувь буюу 4,24 оноотой үнэлэгдлээ.

#### **Гурав: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ**

##### **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2022 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 83,8 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэгдсэн байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг тайлангийн ирцийн үнэлгээ, чанарын үнэлгээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэл хяналтад авсан байдал гэсэн 3 үзүүлэлтийн дундажаар дүгнэлээ.

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланда хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийтлэг алдаа дутагдал байгаа тул цаашид дараах асуудлуудад анхаарч ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эзэнжүүлж, шаардлагатай шийдвэрт хувийн хэрэг нээж, хувийн хэргийн бүрдлийг ханган, баяжилт хийж ажиллах.

-Өмнө нь гарсан шийдвэр, шийдвэрийн заалтыг нэг бүрчлэн шүүн үзэж хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасах, хэрэгжилт тогтмолжсон, байнгын шинжтэй шийдвэрүүдийг дотоод хяналтад авах

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлagnаж байгаатай холбогдуулан хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх тал дээр санал, санаачлага гарган хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаатай ажиллаж гүйцэтгэлийг чанаржуулах, бодит үр дүнг нэмэгдүүлэх

-Хэрэгжилт тогтмолжсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, нэг удаагийн шинжтэй шийдвэрийн заалтуудыг тухай бүртгэл хяналтаас хасч байх

-Гүйцэтгэл сайжруулах болон байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлэх

Аймгийн Засаг даргын 2022 оны "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хагас жил тутамд тайлagnаж ажиллахад анхаарах.

**Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 71,2 хувь, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 89,3 хувиар тус тус дүгнэгдсэн байна.

Бодлогын баримт бичгийг тайлагнахдаа зорилтот түвшнийг тодорхойлоогүй арга хэмжээг хэрэгжилтийн явцаар тайлагнаж байгаа нь үнэлгээ бодит биш, төлөвлөлтийн чанар хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хяналтад авахдаа сумандаа хэрэгжүүлж болох, үр дүн гарах арга хэмжээг хяналтад авч, жилийн эхнээс төлөвлөж хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийг батлагдсан журмын хавсралтын дагуу товч тодорхой тайлагнах, журмын дагуу иж бүрэн, тайлагнахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

#### **Дөрөв: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ**

**Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:**

Аймгийн Засаг даргаас 19 сумын Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээг 10 бүлэг 156 арга хэмжээний хүрээнд байгуулж, гэрээний биелэлтийг дүгнэсэн.

Баян-Өндөр сумын гэрээний хэрэгжилт 2022 оны жилийн эцсээр 91,0 хувьтай дүгнэгдсэн байна.

-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын үнэлгээг тооцох аргачлалаар үнэлээгүй.

-Гэрээний 1.1.5-д дээд шатны байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, 1.1.6-д өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг тус тусад нь тайлагнахаар оруулсан боловч адилхан тайлагнасан.

-Зарим арга хэмжээний биелэлтийн хувьд үр дүнг товч тодорхой 2000 тэмдэгтэд багтаагаагүй буюу хэт нуршуу үйл явцыг нэг бүрчлэн дурдаж тайлагнасан (3.2.1, 5.3.2, 7.1.3, 7.1.4) зэрэг алдаа дутагдал байгааг цаашид анхаарч ажиллах.

**Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны гүйцэтгэлийг ирүүлсэн тайлан, мэдээлэлд үндэслэн 88,5 хувийн хэрэгжилттэйгээр үнэлэв.

-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн, албан хаагчдын саналыг тусган боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах

-Хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дунд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд тодорхой тусгаж тайлагнахад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

#### **Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:**

Сумын Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж 89,4 хувиар дүгнэгдэв.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

#### **Сумын Засаг даргын Тамгын газар**

-Зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжилтийг тооцоогүй (маягтын дагуу зорилт бүрийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг гаргаж үнэлгээ тавигдсан байхыг анхаарах, үнэлгээ нь зорилтод хамаарах арга хэмжээнүүдийн үнэлгээний дундаж болно.)

-Нийт арга хэмжээний 90 орчим хувь нь шалгуур үзүүлэлтгүй байгааг анхаарах Газрын харилцаа, барилга, хот байгуулалттай холбоотой 8.1.1, 8.1.2 заалтуудын суурь болон зорилтот түвшний тоон үзүүлэлт тавигдаагүй.

-Зарим арга хэмжээнд шалгуур үзүүлэлт болон суурь түвшнийг сольсон алдаатай

#### Ерөнхий боловсролын сургууль

-Арга хэмжээ хэт жижигдсэн, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ямар асуудал тусгагдсан байх вэ гэдэгт сайтар анхаарах (байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын чанартай, асуудал шийдвэрлэхэд чиглэсэн, тодорхой хөрөнгө шаардлагатай, орон нутгийн хэмжээнд тухайн салбарт баримталж байгаа бодлого чиглэлийг тусгаж, хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон байхад анхаарна)

-Шалгуур үзүүлэлт оновчтой бус, тайлагналтыг хэт нуршуу, үйл явц тайлагнасан.

-Зарим арга хэмжээ, шалгуур үзүүлэлт болон биелэлт харилцан уялдаагүй, Жишээ нь: 5.7, 6.6, 8.2 гэх мэт

-Хэрэгжилтийг тайлагнаагүй тохиолдолд 0 хувиар дүгнэхийг анхаарах. (6.5, 6.7 арга хэмжээнүүд)

-Зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжилтийг тооцоогүй (маягтын дагуу зорилт бүрийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг гаргаж үнэлгээ тавигдсан байхыг анхаарах, үнэлгээ нь зорилтод хамаарах арга хэмжээнүүдийн үнэлгээний дундаж болно.)

#### Соёлын төв

-Үйл ажиллагааны чиглэл, зорилтоо салбарын бодлоготой уялдуулан тодорхойлж, түүнийхээ дагуу үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох шаардлагатай. Үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй байгаагаас тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл оновчгүй байна.

-Хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүн, үр нөлөөг тодорхойлох, тайлангийн чанар, тайлагнолтад сайтар анхаарах

#### Сургуулийн өмнөх боловсролын байгууллага

-Суурь түвшин тодорхойлох аргачлалд суралцах (суурь түвшнийг хүрэх үр дүн байдлаар тодорхойлсон алдаатай)

-Тайлангийн чанарт анхаарах, тайлагналтыг үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тооцож тайлагнэх

#### Эрүүл мэндийн төв.

-Суурь түвшин болон зорилтот түвшин бүгд 100 хувиар төлөвлөгдсөн, шалгуур үзүүлэлтийг хүрэх үр дүн байдлаар томъёолсон алдаатай

-Зорилтын төлөвлөлт хийгдээгүй, биелэлт байхгүй (зорилт бүрт арга хэмжээнүүдийн агуулгыг багтаасан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тавигдсан, түүнийхээ хэрэгжилтийг тайлагнасан байх шаардлагыг анхаарах)

-Арга хэмжээ бүрийн хэрэгжилт, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаах шаардлагыг хангаагүй Жишээ нь: 1.3, 3.3, 3.5 дахь заалтууд гэх мэт

#### Нийтлэг анхаарах асуудал:

-Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, боловсруулалт алдаатай, төлөвлөгөөнд заавал тусгах зорилт, зорилтын суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилт, зорилтот түвшинг тодорхойлолгүй орхигдуулах, мөн зорилтыг хэт товчлох, шалгуур үзүүлэлтийг буруу точёолох дутагдал төсөвт байгууллагууд дээр ажиглагдаж байна.

-Гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлагнахдаа гадаад хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжээгүй, эсвэл хэрэгжилт нь хойшилсон арга хэмжээг журмын дагуу заавал үнэлэх, хэрэгжээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах

-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдтэй сайтар уялдуулж, арга хэмжээний санхүүжилт, шаардагдах хөрөнгийг бодитой төлөвлөх

-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу гадаад хүчин зүйлээс шалтгаалан гүйцэтгэл тасарсан, хойшилсон аливаа ажил, арга хэмжээг 0, 30, 50 хувиар үнэлэхээр тусгагдсан байгаа тул цаашид гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний зорилтыг хангах чиглэлээр шинэ арга зам, боломжийг эрэлхийлэх, ялангуяа цахим хэлбэрийг бүрэн ашиглаж, хэрэгжилтийг хангахад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

**Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хувийн хэвшлийг дэмжсэн байдал:**

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хувийн хэвшлийг дэмжсэн байдлыг 69,0 хувиар дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, хуваарилсан, төсөл, хөтөлбөрүүдийн ихэнх нь үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим хөрөнгийн чанар, ашиглалт, хадгалалт хангалтгүй, удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ажлууд хангалтгүй байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх эжлын санал асуулга авахдаа иргэдийг тэгш хүртээмжтэй оролцуулж, саналын хуудсыг хүртээмжтэй байдлаар тарааж, иргэдийг идэвхжүүлэхэд санаачилгатай ажиллах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын эрэмбэлсэн жагсаалтад иргэдийн өгсөн санал орсон эсэхийг иргэдэд бүрэн мэдээлж ажиллахад анхаарах нь зүйтэй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын хорооны 2022 оны "Дотоод аудит, хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ" 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, (тогтоолын 4, 5, 8 дугаар заалт)

#### **Тав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ**

##### **Байгууллагын ил тод байдлын үнэлгээ:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийг хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтаар батлагдсан "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт"-ийн дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг баримтлан дүгнэв.

Сумын ил тод, нээлттэй байдлын 2022 оны хэрэгжилт үр дүнг ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланд үндэслэж, цахим сайтын хөтлөлт, баяжилт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээлэхээр заасан мэдээлгийн жагсаалтын дагуу цахим сайтыг хөтөлсөн эсэхийг харгалзан 84,3 хувийн хэрэгжилттэйгээр үнэллээ.

Байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээлэхээр заасан мэдээллийн жагсаалтын дагуу хөтлөх, шинэчлэх ажлыг албан хаагчдад хариуцуулж, хяналт тавьж ажиллах, мэдээллийн шинэчлэлтийн хугацаа, мэдээ, мэдээллийн агуулга, алдааг хянаж засварлахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цаашид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан мэдээлэл хариуцагч гэж Төрийн байгууллага, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтад Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана гэж заасны дагуу бүх төсөвт байгууллагууд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

#### **Шударга байдлын түвшний үнэлгээ:**

Шударга байдлын үнэлгээг сумын авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, авлигын эсрэг үйл ажиллагааны талаар цахим сайтад байршуулсан мэдээллийн тоо, чанар гэсэн үзүүлэлтийн дунджаар үнэлж, 81,2 хувиар дүгнэлээ.

Цахим сайтдаа авлигын чиглэлээр цэс нээж, тодорхой мэдээллүүдийг байршуулсан хэдий ч урд оны мэдээллээ шинэчлээгүй, үүсгэсэн цэсний нэр болон байршуулсан мэдээлэл зөрүүтэй, ач холбогдолгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан, цэс үүсгэж мэдээлэл байршуулсан боловч Авлигатай тэмцэх газрын болон шилэн данс, холбогдох яамны сайтыг шууд холбосон зэрэг зөрчил, мэдээллийн шинэчлэл, баяжилт хангалтгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байна.

Цаашид цахим сайтад байршуулвал зохих мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх, мөн авлигын чиглэлээр өдөр тутмын хийсэн ажлуудаа тогтмол оруулах, сумдын Засаг даргаас төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч наратай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр, мөн авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд сургалтын менежер, нягтлан бодогч нарыг хамруулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулдаг болсон тул энэ чиглэлээр тодорхой заалт тусган цэцэрлэг, сургуулийн удирдлагуудтай дээрх албан тушаалтнууд өөрчлөгдхөх, солигдох, ажлаас чөлөөлгөдөх тухай бүр сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэн, ХАСУМ хянуулах, томилогдоноы дараа 30 хоногт ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой заалт тусган, үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй байна.

#### **Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Баян-Өндөр сумын шилэн дансны хөтлөлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 97,0 хувийн үчэлгээтэй дүгнэгдэв.

Сумдын төсөвт байгууллагуудын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ тайлан байршуулсан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шилэн дансны цахим хуудсанд оруулж буй мэдээлэлд иргэн, хуулийн этгээдийн хандалт, хүртээмж ойлголт муу, мэдээлэл ойлгомжгүй, нэг мэдээллийн давхцал ихтэй, систем сар бүр доголдог, санхүүгийн программаас импортолж оруулах хөгжүүлэлт байхгүй, нэг бүрчлэн гараар шилжжүүлдэг, мөнгөний нэгж, нэгдсэн дүн татах томьёо байхгүй зэрэг нь мэдээлэх албан тушаалтны ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт:**

-Зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг тооцож ажилласан бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлтийг 85,5 хувьтай чиэлэв.

-Байгууллагын ёс зүйн зөвлөл болон дотоод хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа тогтолцсонон. Цаашид үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах

-Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх

-Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтолцоого батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт, хэмжил зүйн

газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичиг стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж мөрдөх, хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас, удирдамж гэх мэт баримт бичгийг стандартын шаардлагад нийцүүлэх, байгууллагын архивт албан хаагчдаас баримтыг бүрэн бүрдэлтэй, хугацаанд нь шилжүүлэн авч хэвших, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх.

-Хариутай албан бичигт хяналтын карт хетлэх. Албан бичиг болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хөтлөлтийг бүртгэлийн дэвтэр болон хяналтын картанд тодорхой тусгаж, эргэн мэдэгдсэн байдал тодорхой байх асуудалд анхаарах

**Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ:**

Хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээг эрх зүйн ажлын тайлан, авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлберийн хэрэгжилт, төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дүн, цэргийн штабаас ирүүлсэн сумдын мэдээ тайлан гэсэн б үзүүлэлтийн ирц, чанарын үнэлгээний дунджаар үнэлсэн бөгөөд 85,9 хувьтай дүгнэгдсэн байна.

**Зургаа: Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:**

**Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийн хүрээнд "Тэрбум мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тайланг үнэлгээнд харгалзуулан 86,7 хувьтай дүгнэлээ.

Баян-Өндөр сум нь зорилтот жилийн хүрээнд хогийн цэгээ шинээр хашаажуулж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтуулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авсан сайн жишиг болсон ажил байна.

Журмын 11 дүгээр хавсралтын дагуу шалгуур үзүүлэлтийг тайлагнахдаа суурь түвшингээ тодорхойлоогүй эсвэл буруу тодорхойлсон, хүрэх түвшинг тодорхойлоогүй учраас хийсэн ажлыг үнэлсэн байдал бодит бус, үр дүнг хүрэх түвшинтэйгээ харьцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй нийтлэг алдаа дутагдал байна.

Ногоон байгууламж:

-Сумд. мод тарих газрыг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөндөө тусгах, тарьсан модны усалгаа, арчилгааг хэрхэн шийдэж авч явах тал дээр онцгой анхаарч жил бүр тарьсан модны тооллого зохион байгуулж амьдралтын хувийг үнэн зөв тодорхойлж байх

Цахим шилжилт:

-Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, E-Mongolia системд нэвтрүүлсэн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвх санаачлагатай ажиллах

-“Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” egr.e-mongolia.mn-ийг нэвтрүүлэх, ашиглалтыг эрчимжүүлэх

-Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахад анхаарч ажиллах, төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагчид Кибер

аюулгүй байдлын болон бусад чиглэлээр зохион байгуулагдаж байгаа сургалтад хамрагдах

**Хог хаягдлын менежмент:**

-Сумын төсөвт болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд эх үүсвэр дээр нь ангилан ялгах савыг нэг бүрчлэн байршуулах, ангилсан дахивар хог хаягдлыг аймаг, орон нутгийн дахивар хүлээн авах цэгүүдэд хүргэх горимыг тодорхой болгож тухайн үйл ажиллагааг тогтмолжуулах

-Төвлөрсөн хогийн цэг дээр байгуулсан аюултай хог хаягдлыг устгах цэгт аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ийн дагуу устгаж хэвших

-Иргэд, хүүхэд багачуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, иргэдийн зөв дадал хэвшилтэй холбоотой сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ**